

АВЛИГЫН ЭСРЭГ 2016 ОНД ЯВУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн зорилт арга хэмжээ	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн	Төсөв / мянган төгрөг /
Нэг.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловруулан, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах					
1.1	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулаж, Авлигатай тэмцэх газраас зөвлөмж авах.	Хууль зүйн хэлтэс, Ажлын хэсэг	02 дугаар сарын 15-ны дотор	-Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэлтсийн албан хаагчдын саналыг авах ажлыг зохион байгуулж гарсан саналыг тусган төлөвлөгөөг батлуулсан байна. - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж нөхцөл бүрдэх	
1.2	Батлагдсан төлөвлөгөөг иргэдэд танилцуулах арга хэмжээ	Хууль зүйн хэлтэс	03 дугаар сарын 15-ны дотор	-Төлөвлөгөөг олон арга хэлбэрээр сурталчилсан байна. -Төлөвлөгөөний талаар иргэд мэдээлэлтэй болсон байна. -Есөнбулаг сумын ЗДТГазраар дамжуулан иргэд олон нийтэд таниулах -Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах.	
1.3	Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлагналтыг хугацаанд нь Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Хууль зүйн хэлтэс, ажлын хэсгийнхэн	11 сарын 15-ны дотор	-Хугацаандаа тайлагнасан байх - Төлөвлөсөн зорилт арга хэмжээг хариуцсан хэлтэс бүр бодитой хэрэгжүүлж, тайлан мэдээг хариуцсан чиглэл бүрээр нотлох баримтын хамт сар бүр бүрдүүлж, нэгтгүүлэх. -Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг холбогдох нотлох баримтын дагуу бүрдүүлж ирүүлж нэгтгүүлж гаргуулна.	

1.4.	аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний дүгнэлтийн дагуу үйл ажиллагаагаа сайжруулах	Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс,	Жилдээ	-Аймгийн ЗДТГ-аас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдээр үнэлүүлж, үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлсэн байна. Үнэлгээний дүнд үндэслэн цаашид авах арга хэмжээний талаар тухайн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.	
Хоёр: Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх.					
2.4	Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулна. Үүнд: Авлигын эсрэг олон улсын өдөр, Хүний эрхийн өдрийг тохиолдуулан иргэд олон нийтэд Үндсэн хуулиар бататгасан хүний эрхийн үзэл санаа, шударга ёс хүний эрхтэй салшгүй холбоотой болох талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хүний эрх ба хууль тогтоомжийн хэрэгжилт “ эссэ нийтлэлийн уралдаан мөн авлигын эсрэг ойлголт сэтгэл зүйг бий болгох зорилгоор “Авлигын үйлдэл хүний эрхийг зөрчих хэрэгсэл болох нь” сэдэвт гар зургийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах. Аймгийн Аудитын газартай хамтран “Авлигын эсрэг бид хамтдаа” дэвжээ тэмцээнийг Шүүх, Хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан зохион байгуулна.	Аймгийн ГХУСААЗ, аймгийн ЗДТГ газар, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтан, Дэлхийн зөн Олон улсын байгууллага, ЕБС-ууд,	2015 оны 12 дугаар сард	-Төрийн албан хаагчид болон ЕБС-ын сурагчдын мэдлэг чадвар нэмэгдэж ёс зүй, шударга байдлын түвшин дээшилж, хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Эссэ нийтлэл, гар зургийн уралдааны төсөв 486,0 мянган төгрөг, Авлигын эсрэг хамтдаа дэвжээ тэмцээнд 200,0 мянган төгрөг
2.5	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчилах ажлыг төрийн бүх байгууллагууд зохион байгуулж ажиллана. Үүнд: Мэдээллийн самбар, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, сонсгол, өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал зэрэг орно. Зохион байгуулсан үйл ажиллагааны талаар холбогдох баримтууд буюу оролцогчдын бүртгэл, фото зураг, зохион байгуулсан арга хэмжээний хөтөлбөр, тайлан гэх мэт мэдээллийг баримтжуулсан байна.	Аймгийн Удирдлагууд, Төрийн байгууллагын удирдлагууд, сумдын ЗДТГ, ХЗХ	Жилийн турш	-Сумдын ЗДТГ-аар нийт иргэдийнхээ 5%, төрийн байгууллагууд 150-аас доошгүй иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдээллийг боломжит хэлбэрүүдээр хүргэсэн байна	
2.6	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулж, албан тушаалтанд давхар ажил эрхлэх зөвшөөрөл олгосон талаар судалгааг гаргах;	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын удирдлагууд	Тухай бүр	-Давхар ажил эрхлэлттэй холбоотой судалгааг гаргаж, тухайн мэдээллийг нээлттэй болгосон байна.	
2.7	Боловсруулж байгаа Иргэдийн Төлөөлөгчдын хурлын тогтоолоор батлагдах хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх	Хэлтэс бүр	Тухай бүр	-Боловсруулж байгаа бодлогын баримт бичиг баримт болон	

	хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулан, иргэд олон нийт сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байна.			нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох шийдвэрт иргэдийн саналыг тусгах арга хэмжээг зохион байгуулж ажиллана.Үүнд: хэлэлцүүлэг, утсаар санал авах, facebook, Twitter хуудсаар санал авах - Иргэд олон нийтийн зүгээс Төрийн бодлогын шинжтэй хөтөлбөр, төлөвлөгөөний талаар илүү мэдээлэлтэй болох, санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах явцад хувь оролцоогоо нэмэрлэх боломжтой болно.	
2.8	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт шалгалтын дүн мэдээг цахим хуудсандаа байршуулах.	Аймгийн ЗДТГазар, Санхүү хяналт, аудитын алба	Төлөвлөгөөг 02 дугаар сарын 01-ны дотор цахим хуудсанд байршуулан тухай бүр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулана.	-Төлөвлөгөө, удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажил зохион байгуулагдсан байна. -Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар олон нийтэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байна.	
2.9	эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй төр, байгууллага болон хувь хүний нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсанд байршуулах, мөн үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг цахим хуудсанд тухай бүр ил тод байршуулах;	ТЗУХ, ХШҮ тасаг,	Жилийн турш	-Төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад эрх бүхий албан тушаалтнаас гаргаж буй шийдвэрийг гарсан тухай бүрт цахим хуудас болон боломжит хэлбэрээр олон нийтэд мэдээлнэ. - Иргэд олон нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангагдана.	
2.10	Тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрлийг олгох журам, холбогдох бичиг баримтын жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэнэ	Холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтан, байгууллагууд	Жилийн турш	-Чиг үүргийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллүүд аймгийн албан ёсны цахим хуудсанд байршсан байна. - Иргэд, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчид мэдээллээр хангагдана. Төрийн	

				байгууллагын үйл ажиллагаан дахь хөндлөгийн хяналт сайжирна	
2.11	Төрийн байгууллага, удирдах албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх, удирдлагын шийдвэр боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжилтийг хянах бүхий л үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилго бүхий Нийтийн сонсголыг зохион байгуулах.	Аймгийн ИТХурал Аймгийн ЗДТГазар	Жилдээ	-Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилт хангагдана. - Шийдвэр гаргах хэлэлцэх, батлах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.	
Гурав. Орон нутгийн төсвийг төлөвлөгдсөн зардалд үр ашигтай зарцуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах					
3.11	Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсандаа байршуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс,	Төсвийн зүйл, зардлын тоогоор	-Төсвийн зарцуулалт нийтэд ил тод мэдээлэгдсэн байх - Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна	
3.12	Төсөв, санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийг Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд нь гаргаж тайлагнаж, цахим хуудсанд байршуулах.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс	Сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор	-Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах - Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.13	2016 оны төсвийг байгууллагын цахим хуудаст байршуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс	Хуулинд заасан хугацаанд	-Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах - Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.14	2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь ил тод, нээлттэй болгож, цахим хуудсандаа байршуулах.	Санхүү, төрийн сангийн хэлтэс,	4 дүгээр сарын 1-ны дотор	Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах - Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.15	2016 оны төсөвт нэмэлт орсон талаарх мэдээллийг ил, тод нээлттэй болгох /ороогүй бол энэ талаар мэдээлэх/	Санхүү, төрийн сангийн хэлтэс,	Өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт	-Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах - Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.16	Төсвийн орлого бүрдүүлэлт /Татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/-ийг цахим хуудсанд байршуулах;	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Тухай бүр	-Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах - Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.17	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг гаргаж, цахим хуудсандаа байршуулах	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс	Улирал бүр	-Мэдээллүүдийг цахим хуудас, самбарт нийтэд ойлгогдохуйцаар байршуулах	

				- Хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	
3.18	Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдснаас хойш 7 хоногт багтаан нийтэд мэдээлэх, цахим хуудсандаа байршуулах.	Хөгжлийн бодлогын хэлтэс	Батлагдснаас хойш 7 хоног	-Иргэд олон нийтэд мэдээлэл, хийгдэж, цахим хуудсанд байршуулсан байна.	
3.19	Концессийн гэрээ, концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсандаа байршуулах.	Хөгжлийн бодлогын хэлтэс	7 хоногийн дотор	-Иргэд олон нийтэд мэдээлэл, хийгдэж, цахим хуудсанд байршуулсан байна.	
Дөрөв.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах					
4.20	Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллээр хугацаанд нь мэдээлсэн байх -Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр /төсвийн хөрөнгө оруулалтын задаргаа/ мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Жилийн турш	-Зарлагдсан ажлын тоогоор - Сонгон шалгаруулалтын зар олон нийтэд хуульд заасны дагуу хүрч хэвшсэн байна.	
4.21	Үнэлгээний хороонд сонирхлын зөрчилгүй хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байх	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Жилийн турш	-Ажлын тоогоор - Хөндлөнгийн төлөөлөл ажилласан байна.	
4.22	Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй болгох, цахим хуудсанд байршуулах;	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	-Ил тод байдлыг хангуулах ажлыг зохион байгуулсан байна.	
4.23	тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийг тодорхой бичих/-ийг ил тод, нээлттэй болгох, цахим хуудсанд байршуулах;	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	-Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг тогтмол мэдээлсэн байна.	
4.24	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг ил тод, нээлттэй болгох, цахим хуудсанд байршуулах	Худалдан авах ажиллагааны алба, сумдын ЗДТГ	Тухай бүр	-Иргэд олон нийт танилцах боломж нөхцлийг бүрдүүлсэн байна.	
тав .Хүний нөөцийн ил тод байдлыг хангах					
5.25	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулах /тухай бүр шинэчилсэн /	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Тухай бүр	-Төрийн байгууллагаас Төрийн албаны зөвлөлд сул орон тооны зарыг хүргүүлж, цахим хуудсанд мэдээлсэн байна.	

5.26	Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх.	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Тухай бүр	-Иргэд олон нийтэд мэдээлэл хүрсэн байна. -Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан байна.	
------	--	-----------------------------------	-----------	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР